



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/714

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVII хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XVII/01 тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн “Алтаргана-2024” наадмын бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулагдах хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны ажилд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зар сурталчилгааны ажилд шаардагдах 865,000 (найман зуун жаран таван мянган) төгрөгийг “Алтаргана 2024” наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар захирамжийн хавсралт

“Алтаргана 2024” наадмын лого хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны зардал

№	Шаардагдах зардал	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	“Алтаргана 2024” наадмын лого хэвлэл	80 ш	10,800	865,000
Нийт дүн			865,000	